

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 10-ны өдөр

Дугаар

БА-048/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 22 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 75 (далан тав) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 16 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1.Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/05/09 огноо, БАЗГ2023/220, №0012707 дугаар, 2023/03/01 огноо, БАЗГ2023/038, №0012338 дугаар;

2.2.Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ВА-2022/01;

2.3.Захиалагч: Ньюлонжиен констракшн ХХК оноосон нэр, 9011830847 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5598354 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, 12-12, 99110948 холбоо барих утас,

2.4.Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч: Рэд урбан констракшн ХХК оноосон нэр, 9011789008 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6391826 регистрийн дугаар, БУ11-282/19, БУ11-596/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Их хөлгөн, 3 давхар, 3.1, 88119238 холбоо барих утас, contact@redurban.mn цахим хаяг;

2.5.Барилгын туслан гүйцэтгэгч байгууллага: Эрчим технологи инженеринг ХХК оноосон нэр, 9011594080 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6079423 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 23 дугаар хороо, 4 хэсэг сургуулийн, 1758 тоот, 88066359 холбоо барих утас;

Мэргэнсольюшн ХХК оноосон нэр, 9011290080 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5484987 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7 дугаар хороо, 11 дүгээр хороолол, 7 дугаар гудамж, 6 тоот, 88062276 холбоо барих утас;

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ГАЗАР  
Барилга байгууламжийг ашиглалтанд

Конфидент бьюлдинг констракшн ХХК оноосон нэр, 9011841340 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6892477 регистрийн дугаар, БУ11-737/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 5 дугаар хороо, 10 дугаар хороолол, 49/7, 16 тоот, 91118960, 91114945 холбоо барих утас;

Өрнөх хүч инженеринг ХХК оноосон нэр, 9011487016 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5844096 регистрийн дугаар, ӨБ11-369/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, нарны үйлдвэрийн бүс, 5, 7 тоот, 99990680 холбоо барих утас;

Сайн сайхан констракшн ХХК оноосон нэр, 90111290080 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6132375 регистрийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 5 дугаар хороо, Монел 48, 41 тоот, 99010922 холбоо барих утас;

Голденсет ХХК оноосон нэр, 9011402034 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5692369 регистрийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 2 дугаар хороо, 2 дугаар хороолол, 30, 23 тоот, 99181874 холбоо барих утас,

Уран гагнаас ХХК оноосон нэр, 9011791099 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6402526 регистрийн дугаар, БУ12-537/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, үйлдвэр, 20 дугаар байр, 65 тоот, 91007968 холбоо барих утас,

Титан виндоу ХХК оноосон нэр, 9011816729 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5690048 регистрийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 16 дугаар хороо, 27, 211 тоот, 99091514 холбоо барих утас,

Хос төгс төгөлдөр ХХК оноосон нэр, 9011818576 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6577776 регистрийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, холбоо толгой 6, 66 тоот, 99067992 холбоо барих утас,

Бест оптик сервис ХХК оноосон нэр, 9011818317 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6574041 регистрийн дугаар, 12100450 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,  
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо, 15 дугаар хороолол, 11-20 тоот, 91119851 холбоо барих утас,

Эм жи эл воотор танк ХХК оноосон нэр, 9011693025 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6410324 регистрийн дугаар,

ХЯНАЛ

Барилга байгуу  
ору

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 2 дугаар хороо, 19-р хороолол, 30, 41 тоот, 99111232, 89117797 холбоо барих утас,

2.6.Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Вауин ХХК оноосон нэр, 9011556055 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5989841 регистрийн дугаар, ЗТ11-367/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Өнөр хотхон, 45б, 162 тоот, 99020285 холбоо барих утас;

Скайлайн дизайн ХХК оноосон нэр, 9011451043 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5778549 регистрийн дугаар, ЗТ16-167/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 нарны зам, 62 дугаартай барилгын с-801а тоот, 96300319 холбоо барих утас;

2.7.Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Баатар дулаан хан ХХК оноосон нэр, 9011533104 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5949734 регистрийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо, 44б-р байр, 302 тоот, 99082691 холбоо барих утас;

2.8.Барилга байгууламжийн төлөв байдал: Шаардлага хангасан.

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1.Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 75 (далан тав) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

ШАЛГАЛТЫН  
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс

3.2.Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.3. Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.


3.4. Комиссын акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 7 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 32 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 75 (далан тав) айлын хүчин чадал бүхий үйлчилгээтэй орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, Ньюлонжиен констракшн ХХК-ийн захиалгатай 1 блок, 75 (далан тав) айлын үйлчилгээтэй орон сууц

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч




(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:  
Ньюлонжиен констракшн ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

(Б.Энхтулга)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН 22 ДУГААР ХОРОО, НЬЮЛОНЖИЕН КОНСТРАКШН ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1 БЛОК, ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ 75 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, “Ньюлонжиен Констракшн” ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 1 блок, 75 айлын үйлчилгээтэй орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын нэгдүгээр давхрын үйлчилгээний танхимд 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 16:00 цагт 16 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 18:00 минутанд дуусав.

Хуралд:

- |   |                |
|---|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга                                  | А.Мөнгөн       |
| 2. Нарийн бичгийн дарга: “Ньюлонжиен констракшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал  | Б.Энхтулга     |
| 3. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч | Г.Батбаатар    |
| 4. Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч                   | Э.Цогзолмаа    |
| 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, техник хяналтын инженер  | Б.Цэрэннадмид  |
| 6. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ЗТТ-ийн ахлах инженер   | Б.Оргил        |
| 7. Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны Шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер                                     | Г.Үүрийнгэгээ  |
| 8. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, Дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн   | Н.Болор-Эрдэнэ |
| 9. Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төслийн хяналтын хэлтсийн Дэд хурандаа                    | Ч.Артаг        |
| 10. Барилга хөгжлийн төвийн Барилга, барилгын материал үйлдвэрлэлийн хэлтсийн инженер   | Г.Уртнасан     |
| 11. Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч  | Б.Оюунжаргал   |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагын хүртээмжийн үнэлгээний ажилтан  | Б.Ганбаатар    |

13. Ашиглалт хариуцах Баатар дулаан хан ХХК-ийн Дэд захирал	Х.Мөнгөнсэрээ
14. Зураг төсөл зохиогч “Вауин” ХХК-ийн захирал	Д.Шижир-Эрдэнэ
15. Зураг төсөл зохиогч “Скайлайн дизайн” ХХК-ийн инженер	Б.Нямсүрэн
16. Барилгын ажлын ерөнхий гүйцэтгэгч “Рэд урбан констракшн” ХХК-ийн ерөнхий менежер	Д.Эрхэмбаяр



#### ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 16
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 16

#### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, Ньюлонжиен констракшн ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 1 блок, үйлчилгээтэй 75 айлын орон сууцны барилгын барилгын ажлын гүйцэтгэл ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

#### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн дарга, Барилга техникийн хяналтын улсын ахлах байцаагч

#### **Г.Батбаатар:**

- Барилгад хэрэглэсэн бетоны шинжилгээг үе шат бүрээр үзүүлэх.
- Дээврийн прапетийг хийх.
- Гадна тохижилт, ногоон байгууламжийг зураг төсөлд заасны дагуу хийж дуусгах.
- Зоорийн давхрын цонхны шантанд хаалт, хамгаалалт хийх.
- Гадна зам талбайг хийж дуусгах, авто зогсоол стандартын дагуу хийж, тэмдэг тэмдэглэгээг хийх.
- Техникийн давхарын зураг төсөл өөрчилсөн гүйцэтгэлийн зураг гаргаж үзүүлэх. (8-16 давхар)
- Зоорийн давхрын заслын ажлыг дуусгах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтэцийн стандартын хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч **Э.Цогзолмаа:**

- Дулааны узелийг цэвэрлэж, өнгийн туузаар ороож, хаягжуулах.
- Давхар бүрт байгаа коллекторыг цэвэрлэж хаягжуулах.
- Гадна дулааны худгийн тагыг стандартын дагуу хийх, бэхэлгээ шат хийх.
- Дээвэр дээрх агаар сэлгэлтийн системийн фото зургийг үзүүлэх, бохирын шугамд малгайвч хийх.
- Халаах хэрэгслүүд дээр термостат вентиль суурилуулах.

- 1-3 давхрын айлуудын агаар сэлгэлтийн системийн угсралтыг гүйцээх, ришетка хийх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Барилгын зураг төслийн хяналтын хэлтсийн Дэд хурандаа **Ч.Артаг:**

- Зоорийн давхарт буусан цахилгаан шат болон ерөнхий шатны хонгилд агаарын даралт үүсгэгчтэй гонх хаалтыг хийх.
- 1 дүгээр давхарт зургийн дагуу галд тэсвэржилттэй металл хаалга хийх.
- Техникийн давхар холбоо дохиоллын байгуулалтын зургийн дагуу галын дохиоллыг байрлуулах.
- Зоорийн давхарт цэвэр усны шугамын байгуулалтын дагуу галын дотуур усны шугамыг байрлуулах. /ЦБУ-05/ хуудас.
- Техникийн давхар болон 16 давхарт байнгын шатны хэмжээг засах.
- Техникийн давхарын агаар сэлгэлтийн системийн байгуулалтын ХАС-12 дугаар хуудас зурагт өөрчлөлт орсон зургийн дагуу засах.
- Үүрэг даалгаврын биелэлтийг албан бичиг болон фото зургаар өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, ЗТТ-ийн ахлах инженер **Б.Оргил:**

- Дулааны узелийн тоног төхөөрөмж хаягжуулалт хийх, шугамын дулаалга зориулалтын хомутаар бэхлэх, цэвэрлэгээ хийх.
- Хэрэгцээний халуун усны бойлорын хүчин чадлыг дараагын блокууд ашиглалтад орох үед нэмэгдүүлж, 2 үед холимог схемээр ажилладаг байдлаар зураг төсөлд тусгах.
- Халаалтын дотор системд термостат винтель угсрах.
- Дулаан механикийн зурагт өөрчлөлтийн зураг хийлгэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчлэх албаны Шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Г.Үүрийнгэгээ:**

- 103-р блок барилгын гадна цэвэр, бохир усны шугамын гүйцэтгэлийн зураг хийлгүүлэх, мэдээллийн санд оруулж, акт шалгуулах.
- ЦУХ-1 (холболтын буюу огтолгооны) худгийг цэвэрлэх, дулаалах-фото зураг шалгуулах.
- Гадна цэвэр, бохир усны шугамын ил далд ажлын актыг хангагч байгууллагаар баталгаажуулах.
- Узельд цэвэр усны шугам дээр даралт хэмжигч (монометр) суурилуулах-фото зураг шалгуулах.
- Узелийн өрөө, нөөцийн сав, насос тоног төхөөрөмжийн батлагдсан зураг шалгуулах.
- Нөөцийн савыг угсарч, халдваргүйжүүлэлт хийсэн акт шалгуулах (тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгүүлэх), шатыг хөдөлгөөнгүй бэхлэх. ( $V=45\text{м}^3-1$  ш, зурагт= $61.5\text{м}^3-2$  ш)

- Гадна бохирын усны зассан, өргөтгөсөн ф250мм болгосон шугамын өөрчлөлтийн талаарх зохиогчийн дүгнэлтийг шалгуулж, актыг дахин бичиж, ОСНААУГ-н холбогдох ажилтан болон УСУГ-р баталгаажуулах.
- Ажлын зурагт бохир усны шугамд уналттай худаг байхгүй өөрийн урсгалаар холбогдохоор тусгагдсан байгаа боловч 103-р блок барилын гаргалгаа уналттай холбосон тул баталгаа, тайлбар бичиг ирүүлэх.
- Зоорийн давхарын үйлчилгээний хэсгийн бохир усны насос суурилуулсан эсэх талаар тайлбар бичиг ирүүлэх.
- Бохир усны худгуудийн тагийг хөдөлгөөнгүй бэхлэх.
- Усны тоолуурын заалт авах нөхцөл боломжоор хангах.
- 737/22 тоот техникийн нөхцөл болон ажлын зурагт тусгагдсан цэвэр усны ф100мм-н шугам трасст байсан эсэх лавлагааг авч шалгуулах.
- Цэвэр усны ф250мм-ийн шугамыг нэвтрэх сувагт оруулах ажлыг хийж гүйцэтгэх огноог тодорхой тусгасан баталгаа бичиг ирүүлэх.
- Ундны усны сорьц өгч, дүгнэлтийг шалгуулах. (нян, хими-физик 2 үзүүлэлтээр өгөх)

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Барилга хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын хэлтсийн үйлдвэрлэлийн инженер **Г.Уртнасан:**

- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасан норм, нормативын сангийн төлбөрийг тооцуулж төлөх.
- Зоорийн цонхонд хаалт, хамгаалалт хийх.
- Өөрчлөлтийн зураг төслийг батлуулах.
- Техникийн давхарын өрөөг норм дүрэмд заасан зориулалтын дагуу ашиглах баталгаа гаргах.
- Гадна тохижилт, ногоон байгууламж, автозам хийгдэх хугацааг тодорхой зааж, дулааны улиралд хийж гүйцэтгэх, баталгаа гаргаж ирүүлэх.
- Магадлалын ерөнхий дүгнэлт, барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээнд өргөтгөлийн барилгыг тусгуулж дахин комисс ажлуулах.
- Айлуудын мөргөлдөж байгаа хаалганы онгойх хэсгийг өөрчилж, хэвийн болгох.
- 1-р давхрын гонх зураг төслийн дагуу хийгдэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн Дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн **Н.Болор-Эрдэнэ:**

- Гадна холбооны оролтын худагт шат суурилуулан амалгаа хийх.
- Дотор холбоо дохиоллын актуудыг үнэн зөв болгох (cat 6, cat 5, аль утсаар татсаныг тодорхой болгох)
- Давхрын самбарын хэмжээ зургаас өөрчлөгдөж хийгдсэн байна. (Хэмжээ жижиг болсон). Зургийн дагуу хийж гүйцэтгэх.
- Зоорийн давхарын холбооны өрөөг 1 давхар луу шилжүүлсэн байна. Афторын дүгнэлтэнд өөрчлөлтийг тусгуулах (өөрчлөлтийн батлагдсан зураг шалгуулах)

- Камерийн бичлэгийг хамгийн багадаа 1 сар хадгалдаг байхаар хардны багтаамж нэмэгдүүлэх. (одоо 4тв байна). Хяналтын төхөөрөмжийг цоожтой рампанд байршуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер **Н.Цэрэннадмид:**

- ХТП-252 дэд өртөөг өргөтгөхтэй холбоотой буусан тоноглолыг хүлээлцсэн акт шалгуулах.
- Гадна цахилгаан ЦДКШ-ийн гүйцэтгэлийн бичиг баримт, ил далд ажлын акт шалгуулах.
- Аянгын болон давтан газардуулгын нэргүүлэлт хэмжүүлсэн протокол, хэмжилт, туршилт хийсэн компанийн тусгай зөвшөөрөл шалгуулах.
- Ерөнхий оролтын самбарт хаяг бичиглэл, схем засаж зөв бичиглэл хийх.
- АВР-ын самбарын холболтуудыг шалгаж, зургийн дагуу холболтыг засаж, тоолуур хэмжих хэрэгслийг Баянзүрх хэрэглэгчдэд үйлчлэх төвд бүртгүүлэх.
- Нөөцийн усны сав болон тоолуурыг давтан газардуулгын хүрээнд холбох, хүрээг гүйцэт хийх.
- Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13-н дагуу гадна дэд өртөө, шугам, тоноглолыг хангагч байгууллагад шилжүүлэх хүсэлт ирүүлэх.
- Дээврийн металл хийцүүдийг аянгын торонд холбох, зэврэлтээс хамгаалж будах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Б.Оюунжаргал:**

- Барилга угсралтын тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж, хаягжуулалах (ажлын дараалал нэр бичих)
- Хуулбар баримт шаардлага хангах.
- Барилгын угсралтын ил далд ажлын акт, гэрэл зургийг ажлын дарааллаар ботьлон дотоод товъёог үйлдэн эх хувиар, гарын үсгийн бүрдэл ханган өгөх.
- Өөрчлөлтийн БА зураг ажлын зургаас тусад нь баталгаажуулан эх хувиар өгөх. 1-4 давхарын.
- Барилгын хувийн хэргийг бүрэн бүрдэлтэй бүрдүүлж өгөх.
- Хувийн хэрэгт туслан гүйцэтгэгчийн гэрээ холбогдох баримтыг эх хувиар хийж, бүрдүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөн 3м 95см машин зогсох зай 2м 45см. Тэргэнцэртэй хүн бууж, суух зай 1м 50см эрээн шугам татаж, тусгайрлаж өгнө. Зогсоолын урд 1м 80см шон 60х60 самбар хийнэ.
- Граж руу буусан налууны уртыг стандарт болгон гадаргуйн плитаг хальтардаггүй материаллаар хийх.

- Гадна налуу замын 2 талын бариулын хоорондын зайг 90 см болгож ойртуулах.
- Үйлчилгээний заалны ариун цэврийн өрөөний суултуур, угаалтуур MNS6055 стандартын шаардлага хангасан туслах бариулуудыг суурилуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ашиглалт хариуцсан байгууллага “Баатар дулаан хан” ХХК-ийн Дэд захирал, **Х.Мөнгөнсэрээ:**

- Нөөц усны савны өрөөний шалыг плита болон зориулалтын будгаар будах.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч байгууллага:

“Вауин” ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Д.Шижир-Эрдэнэ:**

- Тухайлсан саналгүй байнгын ашиглалтад авах саналтай байна.

“Скайлайн дизайн” ХХК-ийн инженер **Б.Нямсүрэн:**

- Тухайлсан саналгүй байнгын ашиглалтад авах саналтай байна.

Гүйцэтгэгч байгууллага:

“Рэд урбан констракшн” ХХК-ийн менежер **Д.Эрхэмбаяр:**

- Үүрэг даалгавар байхгүй. Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.

Захиалагч байгууллага “Ньюлонжиен констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал **Б.Энхтулга:**

- Үүрэг даалгавар байхгүй.

Гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулах саналтай байна.


Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **А.Мөнгөн:**

- Зураг төсөл зохиогч “Скайлайн дизайн” ХХК-ийн комиссын гишүүнээр ажилласан Б.Нямсүрэнгийн тус байгууллагад харъяалагдах мэдээллийг ирүүлэх.
- Гадна тохижилт, ногоон байгууламж зам талбайг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэж хийх хугацаа бүхий баталгааг албан бичгээр ирүүлэх.


Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, "Ньюлонжиен констракшн" ХХК-ийн захиалгатай зорьтой 16 давхар 1 блок, үйлчилгээтэй 75 айлын орон сууцны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах ашиглалтад оруулах.



Танилцсан:  
Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан  
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Тэмдэглэл хөтөлсөн:  
Ньюлонжиен констракшн ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



(Б.Энхтулга)